

## М. ДҮГЭРСҮРЭН БА БНМАУ-ЫН АЗИ, НУБ-ЫН ТАЛААРХ БОДЛОГО

*Б. Должинцэрэн\**

**Т**а бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье. Өнөөдрийн бага хуралд оролцож Дүгэрсүрэн сайд агсны тухай товч ярихаар бэлтгэсэн. Дүгэрсүрэн сайд агсан Гадаад яамны сайдаар ажиллаж байхад цаг үе бол өөр байсан. Тэр үед дэлхий ертөнц хоёр туйлд хуваагдаж олон улсын харилцааны аливаа асуудалд үзэл сурталжсан байр сууринаас ханддаг байсан үе. Гэвч тэр хүний явуулж байсан бүхий л үйл ажиллагаа нь олон улсын тавцан дээр эх орныхоо нэр хүндийг өргөж хамгаалах, жижигхэн Монгол улсынхаа гадаад харилцааг бүхий л талаар бэхжүүлэн хөгжүүлэхэд чиглэгдэж ирсэн. Энэ талаар түүний гаргаж ирсэн түүний нөр их хүчин зүтгэл өнөөдөр ч бид бүхний сэтгэл зүрхэнд хадгалагдаж бидэнд үлгэр дуурайл болсоор байна.

Ялангуяа энэ нь Монгол улсаас Ази тивд явуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, энэхүү уудам бүс нутгийн улс орнуудтай манай харилцаа хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх талаар түүний гаргаж байсан хүчин чармайлт, байгуулсан гавьяа зүтгэлээс бэлэхнээ тодорхой харагдах юм.

Энэ тухай хэд хэдэн гол гол баримт жишээг дурдан ярьж болох байна.

1. Дүгэрсүрэн сайд Гадаад яамыг тэргүүлж байх хугацаанд манай орон Азийн олон орон тухайлбал 20 шахам улстай дипломат харилцаа тогтоосон. Үүнийг зориуд судалж үзсэн. Тэр үед Азийн зарим орон нь колонийн дарлал дор ч байсан. Колонийн дарлалаас ангижирч тусгаар тогтнолоо олж авмагц манай орон тухайн улсыг хүлээн зөвшөөрч харилцаа тогтоож байсан.

2. Монгол улсаас Азийн том гүрэн Энэтхэгтэй харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Дүгэрсүрэн сайд биечлэн оролцож онцгой үүрэг роль гүйцэтгэсэн. Тухайлбал Дүгэрсүрэн сайдыг Гадаад яамны орлогч сайд байхад манай улс Энэтхэгтэй дипломат харилцаа (1955 онд) тогтоосон. Тэр үед Азийн 2 том орон ойр дотно байж,

\* Гадаад хэргийн сайдын зөвлөх, Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд, доктор

Хятад зуучилсан гэж ярьдаг. Тухайн үеийн дипломат харилцаа тогтоосон анхны социалист бус орон (тухайн үед) бол Энэтхэг байв. Дараа нь Дүгэрсүрэн сайд Энэтхэгт элчин сайдаар ажилласан. Энэтхэг бол дэлхий дахины улс төрийн бодлогод жин дарсан орон. Дүгэрсүрэн сайдыг Энэтхэгт ажиллаж байхад хоёр орны харилцаа улам бэхжив. Энэтхэг улс Монголыг НҮБ-д элсүүлэх асуудлыг хамгийн идэвхтэй шаргуу дэмжсэн. Үүний жишээ бол Неругийн 1960 онд НҮБ-д хэлсэн үг юм. Жавахарлал Неру хэлэхдээ: “Бид НҮБ-д өчнөөн олон орныг зүй ёсоор оруулж байгаа үедээ яагаад Монголыг гадна нь орхих ёстой юм бэ? ... Тэнд номхон дөлгөөн бөгөөд энхийг эрхэмлэсэн ард түмэн, хөгжил дэвшлийнхээ төлөө шургуу зүтгэж байгаа. Түүнийг (Монголыг) энэ их байгууллагад оруулахгүй байх нь аль ч талаас нь авч үзэхэд зарчмын хувьд туйлын буруу юм гэж би бодож байна... Үндэстнүүдийн Дэлхийн Чуулгад Монголыг хүлээн авах ёстой гэж би үнэхээр зөвлөж байна” гэсэн билээ. Энэ үг бол Энэтхэг, Монголын харилцаа хичнээн ойр дотныг харуулж байна. Ийм ойр дотно харилцаа тогтоход Энэтхэгт сууж байсан Дүгэрсүрэн сайдын гавьяа зүтгэл мэдээж нэн их.

3. Дүгэрсүрэн сайд агсан Азийн гол гол орнуудтай Монгол улсын харилцаа, хамтын ажиллагааг цааш нь гүнзгийрүүлэн өргөтгөхөд мөн өөрөө биечлэн оролцож чухал үүрэг роль гүйцэтгэсэн. Гадаад яамны сайд байхдаа, сайдын хувиар Азийн гол гол орнуудад айлчилсан. Тухайлбал Япон, Индонези, Вьетнам, Балба, БНАСАУ, мөн Энэтхэг гэх мэт олон оронд айлчилсан. Энэ айлчлалынхаа явцад Монгол орон, Азийн харилцааг цаашид өргөтгөн хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж иржээ. Эдгээр айлчлалын үед цаг үе нэлээд өөр байсан боловч айлчлалын баримт бичигт Азийн орнуудын хоорондох харилцааг хэвийн болгохын төлөө санаа тусгагдаж ирсэн. Жишээ нь Вьетнамд хийсэн айлчлалын баримт бичигт Хятадтай харилцаагаа хэвийн болгох нь чухал гэдгийг хоёр тал тэмдэглэж байв. Мөн Энэтхэгт хийсэн айлчлалын үеэр Энэтхэг, Хятадын харилцааг хэвийн болгохын чухлыг тэмдэглэж байв. Энэ бүхэн нь өнөөдөр биеллээ олсныг бид харж байна. Түүгээр үл барам Хятад, Орос, Энэтхэгийн гурван талт харилцааны эхлэл тавигдаж байгаа, Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага буй болсон зэрэг нь Дүгэрсүрэн сайд агсан Азийн улс гүрнүүдийн харилцааг хэвийн болгохын чухлыг тэмдэглэж байсан нь өнөөдөр биеллээ олжээ гэж хэлж болно.

4. Дүгэрсүрэн сайд Азийн асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч ирсний бас нэг жишээ нь түүний НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган дээр болон бусад олон улсын хурал чуулган дээр хэлсэн үгнээс тодорхой харагдаж байв. Тэрээр бараг үг бүртээ энэ

тивийн тухай тодорхой ярьж Ази тивд энх тайван хамтын ажиллагааг эрхэмлэн хөгжүүлэхийг тэмдэглэдэг байв. НҮБ-ын индэр дээрээс хэлсэн үгэндээ тусгаж байсан Азийн асуудлаарх олон чухал саналууд бий. Түүнээс нэгийг нь жишээ болгон дурдахад Монгол улс 2-р дайны үед болон уг дайны төгсгөлөөр Ази, Алс Дорнодод НҮБ-ын талд идэвхтэй оролцож ирсэн. Энэ утгаараа Монгол улс НҮБ-ыг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг тэмдэглэж байсан. Ер нь Монгол улсаас Азид явуулах бодлогын үндэс суурийг тавихад М. Дүгэрсүрэн агсан нэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэх үндэстэй.

5. Дүгэрсүрэн сайд манай улс 1981 оны 5-р сард дэвшүүлсэн “Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх конвенц” байгуулах Монголын саналтай холбогдуулж их зүйл хийсэн. Парламентаас уриалга гаргах, бүх оронд илгээлт явуулах зэрэг ажлыг гардан зохион байгуулж байсан. Жишээ нь Вьетнам зэрэг орноос дэмжинэ гэсэн хариу ирж байсан.

Дүгэрсүрэн сайд агсны үйл ажиллагааны үлэмж хэсэг нь НҮБ-тай холбоотой байсныг мөн тэмдэглэх ёстой. Энэ талаар түүний хийсэн зарим зүйлийг дурдьяа.

- Дүгэрсүрэн сайд агсан Монголоос НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчөөр 2 удаа, тухайлбал 1968-1972, 1988-1990 онуудад, мөн НҮБ-ын Женев дэх салбарын дэргэд суугаа байнгын төлөөлөгчөөр 1972-1976 онуудад тус тус ажиллаж, Монгол орныхоо нэр хүнд, олон улсын байгууллагын үйл ажиллагаан дахь оролцоог идэвхжүүлэн нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гавьяатан билээ.
- Дүгэрсүрэн сайд 1962-1991 онд нийтдээ 30 шахам жилийн хугацаанд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн нийт 30 гаруй удаагийн ээлжит болон тусгай чуулганд өөрийн биеэр оролцож ирсэн юм. Монгол улсын дипломат үйл ажиллагааны түүхэнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ийм олон удаагийн чуулганд оролцож байсан гавьяатан байхгүй билээ.
- Дүгэрсүрэн сайд агсан нь НҮБ, түүний гол болон салбар байгууллагуудын үйл ажиллагаанд зүгээр нэг төлөөлөгч төдийгээр ололцож байгаагүй. Харин тэрээр эдгээр байгууллагын ажиллагаанд оролцоходоо өөрийн биеэр илүү их идэвх чармайлт гаргаж, санал санаачлага дэвшүүлэн батлуулж байсныг зориуд тэмдэглэх хэрэгтэй. Зөвхөн нэг жишээг дурьдахад Химийн зэвсгийг дайнд хэрэглэхийг хориглосон 1925 оны Женевийн протоколын 45 жилийн ой,

НҮБ байгуулагдсаны 25 жилийн ойг угтаж уг протоколд нэгдэн орохыг уриалсан шийдвэрийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар гаргуулж байсан юм. Улмаар дээрх уриалга, санамжийн (рекомендацийн) дагуу нилээд хэдэн орон Женевийн 1925 оны протоколд нэгдэн орж байсан билээ.

- Монгол улсаас НҮБ дахь хөгжиж байгаа орнуудын бүлэглэлүүдийн үйл ажиллагаанд нэгдэх эхлэлийг тавихад М. Дүгэрсүрэн сайд агсан идэвхтэй оролцож байсан. Жишээ нь Хараред болсон Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний дээд хэмжээний уулзалтад Гадаад Хэргийн сайд агсан Дүгэрсүрэн анх удаа ажиглагчаар оролцсон. Түүнчлэн М. Дүгэрсүрэн хоёрдахь удаагаа НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчөөр ажиллаж байхад манай улс хөгжиж байгаа орнуудын бүлэглэл болох 77-гийн группэд гишүүнээр нэгдэн орсон юм.
- Дэлхий дахинд ардчилал, хүний эрхийг дээдлэн, зах зээлийн харилцааг эрхэмлэх давалгаа өрнөж эхэлсэн 1980-аад оны хуучдаар хүн төрөлхтний энэхүү алхааг М. Дүгэрсүрэн агсан мөн дэмжин талархаж байсан юм. Үүнтэй холбогдсон ганц нэг жишээг дурдъя. 1989 онд олон улсын эдийн засгийн асуудлуудыг хэлэлцдэг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2-р хороонд АНУ-аас санаачлан оруулсан хувийн секторыг дэмжих тогтоолд манай төлөөлөгч хамтран зохиогчоор орох санал тавихад Байнгын төлөөлөгч М.Дүгэрсүрэн агсан дэмжиж байсан юм. Улмаар энэ нь Монгол улс, АНУ-тай хамт хоёул анх удаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолыг хамтран зохиогч болсон түүхэн дэх анхны тохиолдол болсон юм.

Дээр дурьдсаныг дүгнээд хэлэхэд 17 жилийн турш Гадаад Яамыг тэргүүлэн ажилласан М.Дүгэрсүрэн сайд агсны үйл ажиллагаанд Азийн асуудал, түүнчлэн Монгол улсын НҮБ-тай харилцах хоёр том бүлэг асуудал чухлаас чухал байр суурь эзэлж ирсэн нь тодорхой байна.

М. Дүгэрсүрэн сайд агсан энэхүү хоёр бүлэг асуудлаар Монгол улсын нэр хүндийг өндөрт өргөн идэвхтэй ажиллаж байсан юм. Энэ нь тэрээр эх орныхоо үйлсийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж ирсэн гавьяатан болохыг харуулах нэгээхэн жишээ мөн билээ.